

МОНГОЛ УЛС ДАХЬ ИСЛАМЫН ШАШНЫ ТҮҮХ, ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДЛУУД

*М.Хурметхан**

Ислам шашин нь дундад зуунаас Монгол нутагт дэлгэрч, тус орны нийгэм, эдийн засаг, улс төрийн бодлого, оюун санааны амьдралд нэвтрэн нөлөөлж байлаа. Ийм үйл явцын нөлөөгөөр Монгол улсын хүн амын тодорхой хэсэг нь исламын шашныг шүтэж баримталдаг болсон юм.

Монголын нийгмийн байгуулал үндсээрээ өөрчлөгдсөн сүүлийн арав гаруй жилд Монголд байсан шашнууд дахин сэргэж, ардчилал, зах зээлийн шинэ нөхцөл байдалтай уялдаж, манай оронд ислам шашин шинэ байдлаар өрнөн хөгжиж байна.

Монгол улсад ислам шашны асуудлыг судлах танин мэдэхүй, онол, сургалт боловсролын хэрэгцээ шаардлага, практик, улс төрийн бодлогын тодорхой, прагматик хэрэгцээний аль нь ч үүсэн гарч байгаа.

Баян-Өлгий аймаг, мөн бусад олон аймагт аж төрдөг казах, хотон иргэд ислам шашныг түүхийн уламжлалт ёсоор шүтэн баримталж, тэр нь одоо үед улам сэргэн идэвхжиж байна.

Монгол Улс гадаад харилцаандаа нээлттэй бодлого явуулж ислам шашин дэлгэрсэн, исламын ертөнцийн олон оронтой эдийн засаг, улс төр, соёлын талаар харилцан хамтран ажиллаж байна.

Монголын мусульманчуудын түүх, ялангуяа тэдний шашин шүтлэгийн эзлэх байр суурь зэрэг нь зохих ёсоор судлагдаагүй байгааг хэлэх хэрэгтэй. Манай орны мусульман иргэдийн өнөөгийн төлөв байдал, түүний чиглэл хандлагыг социологийн болон бусад арга хандлагаар нухацтай судлах шаардлагатай юм.

Ислам шашинтай төдийлөн танил биш зарим хэсэг хүмүүс исламыг буруу зөрүү төсөөлж ойлгосон байдаг. Тиймээс Монгол орон дахь ислам шашны талаархи тодорхой асуудлуудыг авч үзэж илэрхийлэн гаргахын хамт эл шашны гол тулгуур үндэс болох Коран судрыг Монгол уншигчдад эх хэлээр танилцуулах нь ч ач холбогдолтой юм.

Монголын мусульманчууд

1. Монголын мусульман хүн амын олонхийг казахууд эзэлдэг. Эдгээр казахуудын өвөг дээдэс XVII зуунд Дорнод Туркестанд

*М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

суурьшин, улмаар 150 жилийн өмнө Алтайн уулын хойт /одоогийн Баян-Өлгий аймаг/ хэсэгт шилжин суурьшсан ажээ. 1923 онд 11200 казах байсан бол 1934 онд 18699 казах бүртгэгдсэн, тэдний 1276 нь Молла буюу бичиг үсэгтэй хүмүүс байв. 1940 онд 25576, 1950 онд 29620, 1963 онд 47,7 мянган казах байв. 1969 онд Монголын бүх хүн амын 5,2% буюу 62,8 мянган казах байв. 1979 онд 84,3 мянган казах байсан бол 1989 онд 120506 болж, Монголын хүн амын 5,9%-ийг эзэлж байв. Улмаар 1991-1994 онудын хооронд 60 мянган казах хүмүүс Казахстанд шилжин суурьшсан бөгөөд Казахстаны Засгийн газрын жил бүрийн квотын дагуу тодорхой тооны хүмүүс Казахстанд нүүдэг ч, буцаж ирдэг хүмүүс ч байдаг.

Монгол Улсад 2000 оны тооллогын дүнгээр 102983 казах оршин амьдарч байна.¹ Тэд Баян-Өлгийгээс гадна Ховд, Төв, Хэнтий, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод байдаг.

2. Монголын мусульманчуудын хоёрдахь хэсгийг хотонгууд эзэлдэг бөгөөд Увс аймаг, Дархан, Орхон хотод оршин суудаг. Эрдэмтэд тэдний гарал үүслийг янз бүрээр тайлбарладаг ч тэд түрэг хэлтэн, ислам шашинтан гэдэгт санал нийлдэг. Тэд ойрдуудад уусаж дөрвөд аялгуутай болсон хэдий ч исламын шашны ул мөр, зан заншилаа хадгалагдан үлджээ. Хотончуудын хүн ам нь 1956 онд 2600, 1963 онд 2900, 1989 онд 6676, 1997 онд 8800 болсон байна. 900 өрх, 5000 хүн нь Увс аймагт төвлөрөн суудаг.

3. Монголын мусульманчуудын гуравдахь хэсгийг уйгарууд эзэлнэ. Тэд XX зууны эхээр ирж, суурьшсан боловч 1956 онд нэлээд нь Синьцзян уруу буцжээ. Одоо Баян-Өлгий, Ховд аймаг, Улаанбаатар хотод уйгурууд цөөн тоотой бий.

4. Монголын мусульманчуудын дөрөвдэх хэсгийг дунгаанууд эзэлдэг. Тэд цөөн хүнтэй бөгөөд ихэнх нь Казахстанд байдаг. Цөөн тооны хожа /араб/, ногай, татар, өзбек гаралтай хүмүүс мөн адил казах хэлтэй бөгөөд исламын шашинтай юм. Тэрчлэн цөөн тооны монгол хүмүүс ч исламын шашинг баримталдаг.

Исламын шашин Монгол дахь казахуудын амьдралд

Монгол улсад ислам шашныг казах угсаатны хэсэг баримталж байна. 1911 онд Чин гүрэн задарч, Гадаад Монгол тусгаар тогтноход Ховдын хязгаарын казахууд тус улсын бүрэлдэхүүнд оржээ. Тус улсын казахын иргэд нийт Монголын ард түмний хууль ёсны, эрх тэгш

бүрэлдэхүүн хэсэг, тэдний шүтэн баримталдаг Ислам шашин нь Монгол улс дахь уламжлалт шашин шүтлэгийн нэг хэсэг мөн.

Монгол дахь казахуудын ислам шашин, түүний эрх зүйн байдал, харилцаа нь Монгол улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулагдаж байна. Энэ хуулинд Ислам шашныг мусульман шашин гэж томъёолон бичжээ. /З-р бүлгийн 7-р зүйлийн 6-д/. Уг шашны уламжлалт албан ёсны нэр нь ислам. /Монголчууд лалын шашин гэдэг. Энэ нь “Аллах” –гэсэн үгийн хувирсан дуудлага/, харин мусульман гэдэг нь уг шашныг шүтэн бишрэгсдийг нэрлэсэн нэр томъёо боловч, монголын хуулинд андууран авсан байна.

Монгол улс дахь казахуудын ислам шашин шүтлэгийн уламжлал, өнөөгийн байдлыг авч үзэхдээ, тэд Монгол оронд хэрхэн, яаж шилжин ирж, оршин суух болсон асуудлыг мэдэх нь чухал юм. Монгол дахь казахуудын түүх, эдийн засаг, хэл, соёлыг судлах асуудал Монгол болон гадаад орнуудын эрдэмтдийн анхаарлын төвд байсаар ирсэн, байсаар байна. Үүний үр дүнд Монгол дахь казах угсаатны салбарыг судлахтай холбоотой судалгааны багагүй ном бүтээл туурвигдажээ.²

Монгол дахь казах угсаатны шашин шүтлэгийн түүхийг ямар нэгэн хэмжээгээр тусгасан угсаатны зүйн материаллаг болон оюуны соёлын дурсгал, археологийн олдвор элбэг бөгөөд тэдгээрийг эрдэмтэд судлан боловсруулж эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулсаар байна. Казахууд аман зохиолын баялаг өв сантай, тэдгээрт исламын шашин гүн гүнзгий тусгагдсан байдаг. Энэ нь Монгол дахь казахуудын шашин шүтлэгийн түүх, тэдний оюун санаанд ислам шашин хэдий үеэс нэвтрэн орж хэвшин тогтсоныг судлан гаргахад тус дөхөм болно.

Казахын ард түмний оюун санаа, материаллаг амьдралд исламын шашин VII-VIII зуунаас нэвтрэн хэвшжээ. Монгол дахь казахуудын өвөг дээдэс одоогийн Казахстан улсын нутагт оршин сууж байсан үед исламын шашныг шүтэж, дэлгэрүүлсэн байна.

Монгол дахь казахуудын өвөг дээдэс нь суугуул нутгаас дорно зүг аажмаар шилжин Дорнод Туркестаны зүүн гурван аймаг, Алтай, Или, Тарбагатайд суурьшихдаа исламын шашнаа үргэлжлүүлэн шүтэн биширч, исламын шашин улам эрч хүчээ авч байлаа. Нүүдлийн казахуудад хот газар шиг сүм хийд байгаагүй боловч, мешит, медресе зэргийг өвөлжөөнийхөө дэргэд байгуулж байв. XIX зууны дунд үед энд ислам сургаал, шаритын хууль өргөн тархаж, шашны ном судар элбэг тархаж байсан. Дорнод Туркестаны Тарбагатай аймагт 1898 онд “Акмешит” байгуулагдсан нь исламын шашин шүтэж дэлгэрэхэд ихээхэн

нөлөө үзүүлэв. Дорнод Туркестаны казахууд оршин суугаа газруудад ХХ зууны эхний хориод жилд 33 мешит нээгдсэн бол, зөвхөн Алтай аймгийн Жеменай, Буыршын, Көктогай, Ерчис мөрний сав газарт 16 мешит нээгдэж, тус нутгийн казахуудын оюуны соёлын төв болж байв.

Энэ үед Орос-Чин улсын хилийн харилцаа, худалдаа идэвхжих болсоноор мешит, медресе соёлын төв хөгжсөн Казахстан, Өзбек, Татарын молла, шашны зүтгэлтнүүд Дорнод Туркестаны казахуудын дунд ирж, ислам шашныг дэлгэрүүлэх, мешит, медресе байгуулах, хүүхэд залуусыг шашны сургуульд хамруулж байв. Үүнд ислам судлаач эрдэмтэн Акым Үлимжиулы Кармсаков Алтайский /1867-1940/, Да Молла Мухаммед Мухмин Ишан Хазарет, Махбубулла, Нугман молла зэрэг хүмүүс ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Монголд суурьшсан казахууд Дорнод Туркестаны Алтай аймгийн казахууд /абак-керей/-аас салбарлан хөгжсөн тул тэдний ислам шашны уламжлал ч тэндээс улбаатай юм. Тэд монголд суурьшсанаас хойш 150 гаруй жил өнгөрч, 4-6 үе солигдсон байна.

Алтайн уулын казахын шүтлэгтнүүдээс 60 гаруй хүн анх удаа 1908 онд Саудын Араб улсын Мекка хотод хажид очсон байна. Монгол дахь казахууд исламын шашны ном судруудыг Оросын Казань, Петербургт хотноо XIX зууны үед хэвлэгдсэнийг худалдаа наймааны хүмүүсээр дамжуулан авч уншиж хэрэглэдэг байжээ.

Казахууд XIX зууны II хагасаас шашин шүтлэг, хэл, соёл ондоо монголчуудын нутагт суурьших болсон үед исламын шүтлэгээ казахууд өөр шашинтай монголчуудаас өөрсдийгөө ялгах үндэсний нэг онцлог, содон шинж, казахын ёс заншил, соёл, аж төрөх ёсоо хадгалах хүчин зүйл хэмээн үзэх болсон байна. Тэд анхны мешит, медресег 1902 онд байгуулж, энэ шашин тэдний аж төрөх ёс, шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, ёс заншлын нэгэн салшгүй хэсэг болж хэвших болжээ.

Баруун Монгол дахь казахуудаас хэд хэдэн удаа бөөнөөрөө Мекка хотыг зорьж ариун шүтээндээ мөргөл үйлдсэний сүүлчийнх 1926 онд болжээ. ХХ зууны эхэн үед тус нутгийн казахууд исламын шашны сургаал номлолыг бүрэн дагаж итгэж биширдэг, энэ нь намаз, хажи, хайыр, зекет, өглөг өгч буян үйлдэн, ораза, рамадан, нас барагсдыг оршуулах гэх зэрэг зан үйл, ёс жаягийг ёсоор нь мөрддөг байлаа.

Тус нутгийн казахуудын дунд энэ үед исламын шашныг дэлгэрүүлэхэд Акыт Улумжиулы Карамсаков Алтайский хосгүй үүрэг гүйцэтгэсэн юм. Тэрээр залуусыг сургахын хамт, амьдрал, уран

бүтээлийн дийлэнхи хэсгийн исламын шашны үйл хэрэгт зориулжээ. Тэрбээр энэ зорилгоор нүүдлийн амьдралтай казахуудад ойлгомжтой болгохын тулд исламын сургаал, номлолоор олон тооны хисса, найраглал, шүлэг бичив.³

Акыт Улумжиулы Карамсаков Алтайский амьдрал, уран бүтээл, үзэл санаа, шашны үйл хэргийг багтаасан эрдэм шинжилгээний намтрыг миний бие бичсэн юм.⁴

1930-аад оны эхэнд Монгол дахь зарим улс төрийн өөрчлөлтийн улмаас шашин, түүний дотор исламын шашинд “эрх чөлөө” олгов. Энэ үед энэ нутагт 7 мечит баригдаж, олон зуун молла бэлтгэгдэв.

МАХН, төрийн зүгээс 1930-аад оны эхэн үеэс шашин, сүм хийд, шашны эсрэг эдийн засаг, улс төр, үзэл суртал, албадлага, хүчирхийллийн шийдвэртэй арга хэрэгслэлээр хатуу бодлого явуулах болсон билээ. Энэ бодлого казахуудын ислам шашны шүтлэгт мөн нэг зэрэг хамаарч шашны боловсрол эзэмшсэн молла нарыг баривчлан хороож угаас цөөн тоотой байсан мечит сүм, дуган, медресе-шашны сургаал зохион байгуулалтгүй болж сарнин аажмаар оршин тогтнохоо больжээ. Ийнхүү казахуудын амьдрал, оюун санаанд ислам шашин зохион байгуулалттай нэвтрэн нөлөөлөхгүй болж хүн ард энэ шашныг урсгалаар шүтэн бишрэх болжээ. 1930-аад оноос хойшхи үед исламын шашин голдуу өндөр настангуудын хүрээнд хүч нөлөөгөө хадгалан үлдэж, залуу үе нь бурхангүйн үзлээр хүмүүжих болсон юм. Энэ үед ислам шашныг өдөр тутам шүтэн баримтлахгүй, ихэнхдээ хүн нас барах, оршуулах, шашны бусад хэвшил болсон зан үйлийн үед л холбогдох ёс жаяг, үйлдлийг баримтлах болжээ. Тухайлбал, намаз, рамадан зэрэг шашны зан үйл хүн амын дунд хүч нөлөө нь суларч 1960-аад оны үед бараг орхигджээ. 1930-1990-ээд оны эхэн хүртэлх 60-аад жилийн туршид шашны хүчтэй нөлөөнөөс тусгаарлагдаж, шашингүйн үзэл, бурхангүйн ёс суртлаар хүмүүжсэн байна. 1985-1986 онд хийгдсэн социологийн судалгааны материалаас үзэхэд Баян-Өлгий аймгаас хамрагдсан ажилчин, малчин, сэхээтэн 280 хүнээс 114 нь буюу 40,7% нь бурхангүйн үзэлтэй гэж хариулжээ. Энэ үед коммунист үзэл суртал ноёрхож, Монгол дахь казахууд ислам шашинтай улс орнууд, тэдний шашны бодлого, нөлөөнөөс тусгаарлагдмал байдалтай байсан үе юм.

Янз бүрийн дарамт шахалт үргэлжилсэн хэдий ч тэднийг ямар ч хүч исламын шашнаас холдуулж чадаагүй юм. Зүрх сэтгэлд нь исламын гал асаж, нийтээр биш ч гэсэн ёс жаягийг гүйцэтгэж байлаа. 1940-1960-аад он хүртэл Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотод ганц мечит

үйл ажиллагаагаа явуулж, сүсэгтэн олонд үйлчилж байсан боловч сүүлд янз бүрийн шалтгаар хаагдсан юм. 1970-аад онд исламын шашны эсрэг шинэ дайралт эхэлж, исламын шашныг казахуудын сэтгэл санаанаас арилгах нь коммунист үзэл суртлын гол зорилго байлаа. МАХН-ын 1978 оны 149-р тогтоол үүний гол нотолгоо бөгөөд Казахуудын амьдрал ахуй, зүрх сэтгэлд хоногшсон зүйл бүрийг хуучны үлдэгдэл хэмээн үзэж, түүнийг бүх хэлбэр, түүний дотор исламын шашны эсрэг тэмцэх хэрэгтэй гэж заажээ.⁵ Исламын шашны эсрэг үйл ажиллагаа мусульманчуудын хүчтэй эсэргүүцэлтэй тулгаран ёс бус зүйлийг таслан зогсоож байв.

Казахуудын исламын өнөөгийн зарим асуудлууд

1990-ээд оны эхнээс монголын нийгмийн оюун санааны хүрээ эрс өөрчлөгдөж, нэг намын ноёрхол, үзэл суртал халагдаж үзэл суртал, ертөнцийг үзэх олон эшт үзэл, хүн ард чөлөөтэй шүтэн бишрэх эрх чөлөө хангагдаж тэдгээрийг Монгол Улсын шинэ үндсэн хууль болон бусад дагалдах хууль, тухайлбал 1993 онд батлагдсан Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар баталгаажуулсан билээ. Энэ нь Монголын бурхан шашин ба бөө мөргөлийн нэгэн адил казах, хотонгуудын шүтдэг ислам шашны эрх зүйн байдлыг баталгаажуулж өгсөн юм.

Эдгээр нөхцөл, хүчин зүйлийн нөлөөгөөр Монгол оронд шашин шүтлэг уламжлалт ёс жаяг, зохион байгуулалтынхаа дагуу дахин сэргэж дэлгэрэх болжээ. Ислам шашин ч сэргэн дэлгэрч хүн амын өргөн хүрээ давхраанд нөлөөлж энэ явцад түүний үзэл номлол, зохион байгуулалт, сургалт сурталчилгаа, нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, нийтлэг ба онцлог шинж, зөрчил бэрхшээл, ахиц ололт ба дутагдал зэрэг нь товойн илэрч энэ шашны өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлагыг судлан шинжилж нэгтгэн дүгнэж болохуйц төвшинд хүрчээ.

Аливаа шашны нэгэн адил ислам шашны нэг чухал бүрэлдэл хэсэг бол түүний ертөнцийг үзэх үзэл, онолын шинжтэй үзэл сургаал, номлолын хэсэг юм. Монгол дахь казах иргэд, сүсэгтэн олны ихэнх хэсгийн шашны ухамсрын бүтцэд шашны цэгцтэй мэдлэг бага, харин сүсэглэж итгэсэн итгэл үнэмшил, шашны психологи давамгай байгаа нь ажиглагдаж байна. Казах хүн амын нийгэм, хүн ам зүйн янз бүрийн хэсэг давхраа, бүлгийг төлөөлсөн 212 хүнээс социологийн судалгааны анкетын аргаар санал асуулга авахад 58 орчим хувь нь ислам шашны

албан ёсны сургаал номлолыг төдийлөн сайн мэддэггүй, тэдний энэ талаархи үзэл төсөөлөл нь бүрэг, тодорхойгүй байгаа нь харагджээ.

Ислам шашны номлол сургаал, зан үйлийн тогтолцоонд эл шашны хамгийн гол, ариун судар болох Кораныг хүндэтгэн хадгалах, уншиж шүтэх, түүний холбогдох хэсэг бүлэг, нас барагсдад зориулж унших явдал чухал байр суурь эзэлдэг. Судалгаагаар хүмүүсийн 8,1 хувь нь Кораныг унших чадвартай, 34,2 хувь нь гэртээ хадгалж нандигнадаг, 6,3 хувь нь Кораныг одоо л олж авах хүсэлтэй, 8,1 хувь уншиж сурч эхэлж буй, 48,6 хувь нь уншиж чадахгүй гэжээ.⁶ Хүн нас барсны дараа түүний хойтохыг даатгаж, түүний сүнс нэрэнд зориулж Коран судрыг Молла нараар бүтнээр нь уншуулах явдал монголын казахуудын ислам шүтлэгийн нэг онцлог ажээ.

Монголын казах иргэд, сүсэгнүүд Коран судрыг уламжлал болгож эртний араб хэл дээр уншиж шүтэж ирсэн бөгөөд шашны боловсрол эзэмшсэн тусгай молла нараас бусад жирийн хүмүүс түүний утга агуулга, казах хэл дээр чухам юуны тухай өгүүлсэн байгааг мэдэхгүй иржээ. Харин 1990 оны эхэн үеэс Коран судрыг орчин үеийн казах хэл дээр хөрвүүлэн кирилл үсгээр хэвлэн нийтэлж олны дунд түгээх болсон юм. Энэ нөхцөлд араб хэл дээр зөвхөн үгчлэн цээжилж харин утга агуулга, юуны тухай өгүүлснийг мэдэхгүй ирсэн сүсэгтнүүд түүнийг казах хэл дээр уншиж танилцахад сэтгэл санаа, итгэл үнэмшил, үзэл бодлын хувьд зөрчилтэй, эргэлзээтэй, Коран сударт сүсэглэн итгэх, үл итгэх хоёрдмол байдалтай болж байгаа тал байна.

Хүмүүсийн шашин шүтлэг, үзэл ухамсар нь тэдний шашны зан үйл, мөргөл, зан байдлаар илэрдэг жамтай.

Намаз нь шүтлэгтнээс шашны зохих мэдлэг, шашны ном уншлагыг цээжилж уншихыг шаарддагаас гадна өдөрт тогтмол таван удаа гүйцэтгэж мөргөдөг нарийн дэг жаягтай зан үйл юм. Судалгааны мэдээгээр сүсэгтнүүдийн дотор намаз мөргөл үйлдэгчид цөөхөн байна. Судалгаанд хамрагдагсдаас 5,4 хувь нь намаз уншиж мөргөл үйлддэгийн бараг бүгд нь 50-60-аас дээш насны хүмүүс байна. Судлагдагсдын 3,6 хувь намаз уншиж мөргөл үйлдэх ёс жаягийг одоогоор эхэлж сурч байгаа хүмүүс, 51,3 хувь нь цаашдаа намаз уншиж мөргөл үйлдэх бодол санаатай.⁷

Ислам шашны дараагийн нэг гол зан үйл, шүтлэг, мөргөлийн илрэл болох ораза устау буюу рамадан сахих зан үйлийн хувьд судалгаанд хамрагдагсдын 7,2 хувь нь жил бүр мацаг барьдаг ажээ. Өлгий хотын төв мешитийн молла нарын үзэж байгаагаар аймгийн

казах иргэдийн 30-аад хувь нь мацаг барьдаг гэсэн мэдээ байна. Мацаг барьж мөргөл үйлдэгчид бараг бүгдээрээ 50-60-аас дээш насных юм. Харин 70,2 хувь нь мацаг барьдаггүй, одоогоор мацаг барих бодол санаагүй хүмүүс юм.

Ислам шашныг шүтэгч мусульманчуудын өөр нэг ариун үүрэг болох хажьд очиж мөргөл үйлдэх зан үйлийг Монголын казахууд тэр болгон гүйцэтгэж чаддаггүй, зөвхөн гүнзгий сүсэгтэн, хөрөнгө чинээтэй хүмүүс л гүйцэтгэдэг байлаа. Монголын мусульманы нийгэмлэгийн санаачлага, зуучлалаар бүх зардлыг нь Саудын Араб улсын шашны байгууллагууд дааж 1992 оны 5-р сард Монголоос 15 хүн, 1998 оны 5-р сард 9 хүн Мекка, Мединд очиж мөргөл үйлдэж хажь цолыг хүртэж иржээ. Энэ бол Монголоос 1926 оноос хойш хажьд очсон анхны мөргөлчид юм.

Монгол оронд шашин шүтлэг чөлөөтэй болсон сүүлийн хэдэн жилд шашны байгууллага, шашны сургуулиуд сэргээгдэж, хүн амын дунд өөрийн үйл ажиллагааг идэвхтэй явуулах болсон нь Баян-Өлгий аймагт ч адилхан байна. Хүмүүс мешит, медресе, сургалт, молла нарын үйл ажиллагаа, нөлөө, арга хэмжээг ямар нэг хэлбэр хэмжээгээр мэдэрч тэдэнтэй харилцаатай холбоотой болсон байна.

Монгол дахь ислам шашны байгууллага нь зохион байгуулалт бүтцийн хувьд дараах байдалтай юм. 1990 онд байгуулагдсан Монголын мусульманы нийгэмлэг нь Монгол дахь ислам шүтлэгтнүүдийн олон нийтийн байгууллага бөгөөд гол нь ислам шүтлэгтнүүдийн шашны эрх ашгийг илэрхийлэн хамгаалдаг, Монгол дахь ислам шашин, мешит, сургалтыг Исламын орнууд, ислам шашны олон улсын байгууллага, төвүүдтэй холбож энэ талын арга хэмжээг тэдгээр орнуудын тусламж хандиваар санхүүжүүлэхэд голлон анхаардаг. Монгол Улс дахь Ислам шашны төв нь Өлгий хотод одоо үйл ажиллагаа явуулж буй Абубакир Салдых Хазретын нэрэмжит мешитэд төвлөрөн ажиллаж байна. Эл төв нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх ислам шашны үйл ажиллагааг удирдан зохицуулдаг байна.

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт 1921 оны өмнөх үед, түүний дараа барагцаалбал 1930-аад оны сүүлч хүртэлхи үед их, бага 14 мешит, 5-6 медресе баригдаж шашин мөргөлийн болон сургалтын төв болж байснаа улс төр, үзэл суртлын хавчилга шахалтаар үйл ажиллагаагаа зогсоож аажмаар байшин барилга нь нурж устгагдсан байна. Өлгий хотод анхны шинэ мешит 1992 оны 11 сард ашиглалтанд орж эл мешитийн барилгын ажлыг Пакистан улсын иргэн, шашны

зүтгэлтэн Мухаммад Хандан гэдэг хүн төгрөгийн тухайн үеийн ханшаар зургаан сая төгрөгөөр санхүүжүүлж бариулжээ.

Монголын бурхан шашны гол төв Гандантэгчинлэн хийдээс хандив болгож 1,5 сая төгрөг өгчээ. Одоогоор Монгол Улсын нутаг дэвсгэрт зориулалтын барилга байгууламжтай 6 мешит ажиллаж байна. Тэдгээр нь Өлгий хот, Дэлүүн сум, Ховд аймгийн Булган сум, Налайх хотод байна. Өлгий хотод өөр нэг мөргөлийн мешит барьж байгаа ба мөн Мухаммад Хандан 3 сая төгрөгийн тусламж өгчээ.

Монголын Ислам шашны төвийн зүгээс тогтмол зохион явуулж буй үйл ажиллагаа, ажлын нэг томоохон чиглэл бол шашны сургалт, боловсрол эзэмшүүлэх явдал мөн. Монголын казахуудын дунд Ислам шашны сонгодог боловсролтой молла нарын үе эдүгээ шувтарсан, тийм учраас шашны сэргэлт, сүсэгтнүүдийн эрэлт хэрэгцээний дагуу зохих мэдлэг боловсролтой залуу молла нарыг шашны сургалтаар бэлтгэх, түүнчлэн сүсэгтнүүдийн өөрсдийнх нь хүсэлтээр тэднийг түр курс сургалтанд хамруулах явдал чухал болоод байна. Монголын Ислам шашны төвөөс энэ дагуу шашны сургалтыг аймгийн төв, сумууд, Улаанбаатар, Налайх, Ховд, Сэлэнгэ аймгийн хэд хэдэн сумуудад жил бүр тогтмол нээж хичээллүүлж олон мянган хүүхэд залуучуудыг түүнд хамруулж байна. Исламын улс орнууд, Турк, Саудын Араб, Пакистан, Казахстан улсад мэргэжил эзэмшүүлэх зорилгоор олон арван оюутан залуусыг сургасан ба сургаж байна.

Монголын мусульманы нийгэмлэг, Монголын ислам шашны төвөөс Арабын орнууд, Исламын ертөнцтэй нягт хэлхээ холбоотой, харилцаатай байж санхүүгийн тусламж авах, сурах бичиг, гарын авлага авах чиглэлээр гадаад үйл ажиллагаагаа явуулж байна. Ялангуяа Саудын Араб, Казахстан, Кувейт, Египет, Пакистан, Турк улстай шашны талаар нэлээд нягт холбоотой ажиллаж байна.

Эдүгээ үед Христос шашин, түүний томоохон байгууллага, урсгал, төвүүдийн зүгээс хуучны социалист орнуудын хүн амын шүтэн бишрэх эрх чөлөөг хуулиар хамгаалж баталгаажуулсан, эдгээр оронд нийгмийн оюун санааны амьдрал, хүн ардын үзэл ухамсарт оршин үйлчилж байсан марксист-ленинист үзэл суртал халагдаж түүний оронд бий болсон хоосон зайг эзлэх, христос шашны элдэв олон урсгал чиглэлийг Монголд сурталчилж түгээн дэлгэрүүлэх оролдлого хийж байгаа билээ. Тийм үйл ажиллагаа Баян-Өлгий аймагт ч хүрчээ. 1993 оны хавар Герман улсаас Христос шашныг сурталчлан дэлгэрүүлэгчид Улаан загалмайн нийгэмлэгийн чиглэлээр тусламжийн бараа хүргэх

завшааныг ашиглаж эхлээд хүмүүсийн эрүүл мэндийг үзэх, өвчтөнүүдийг эмчлэх нэр хэлбэрээр тэдэнд Христос шашныг сурталчилж Библи судрыг казах хэл дээр тарааж зураг хөрөг авчээ. Энэ үйл хэргийг Монголын мусульманы нийгэмлэгийн зүгээс, мешитийн зүгээс эсэргүүцэж олон нийтийн цуглаан зохиож тэднийг шийдэмгий няцааж, хөөн явуулжээ. Христос шашныг Казахуудын дунд сурталчлах, дэлгэрүүлэх оролдлого 1998 онд дахин давтагдаж мөн ахиц ололтонд хүрээгүй. Нөгөөтэйгүүр цөөн тоотой казахууд ислам шашин шүтэх явдал бол казах угсаатан байгаагийн нэг чухал шинж тэмдэг хэмээн үздэг учраас монголын казахууд өөр шашин шүтлэгт ордоггүй, тийм явдлыг шашин мешит төдийгүй эцэг эх, ах дүү, бусад хүмүүс эрс эсэргүүцдэг онцлогтой. Гэхдээ казахууд нэг дор олон жил эв найртай хамтран аж төрж ирсэн адилхан эсгий туургатай урианхай, дөрвөд, тува ястнуудын бурхны шашин, сүсэг бишрэлийг хүндэтгэж ирсэн, тэднийг шашин шүтлэгээр нь хавчиж гадуурхсан, шашнуудын хооронд зөрчил сөргөлдөөн гарсан тохиолдол байхгүй байна.

Шашны байгууллагын үйл ажиллагаа, авч буй арга хэмжээ, зохиож буй ажил төрөл нь түүний материаллаг бааз суурь, санхүү мөнгөний чадал чансаанаас ихээхэн шалтгаална. Монгол Улс дахь ислам шашны үйл ажиллагааг бүхэлд нь Монголын мусульманы нийгэмлэг хариуцаж сүсэгтнүүдийн өглөг хандиваар санхүүжүүлж байна. Мешитүүд тийнхүү өөрөө өөрийгөө санхүүжүүлж илүү гарсан зээлээ ядуу, зүдүү, өнчин өрөөсөн, өвчтэй зовлонтой хүмүүст тусламж болгон өгдөг. Мешитүүд үйл ажиллагаагаа идэвхжүүлж өргөжүүлэх, шашны сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэхэд багагүй хэмжээний төсөв мөнгө хэрэгтэй болж байна.

Социологийн судалгаанд хамрагдагсдын 52,2 хувь нь аймгийн хэмжээнд ислам шашин ёс журмаараа сэргэж хүн ардад ач тустай үүрэг гүйцэтгэж байна гэжээ. Гэхдээ хүмүүсийн тодорхой хэсэг нь ислам шашны одоогийн байдалд шүүмжлэлтэй ханддаг нь ажиглагдав. Жишээлбэл: судлагдагсдын 41,4 хувь аймгийн хэмжээнд ислам шашин шүтлэгийг өөрийнх нь ёс жаяг, уламжлалынх нь дагуу сэргээж баримталж чадахгүй байна, 48,9 хувь нь молла нарын шашны эрдэм мэдлэг, олны дундах нэр хүнд дунд зэрэг, түүгээр ч үл барам зарим талаар тааруухан, доогуур байна гэж үзжээ. Судлагдагсдын 69,3 хувь нь мешитүүд үйл ажиллагаа, үүргээ хэвийн сайн гүйцэтгэж байна, 58,5 хувь нь шашны сургууль, сургалт боловсрол сайн байгаа гэж үнэлжээ. Үүний зэрэгцээгээр судлагдагсдын 31,5 хувь нь мешитүүдийн шашин

номын үйл ажиллагаа явуулж буй ажил, арга хэмжээ нь дунд зэрэг, 26,1 хувь нь шашны сургууль, сургалт боловсролын байдал дунд зэрэг гэж дүгнэсэн байна. Олон тийнхүү ислам шашны өнөөгийн байдал, мешит, медресе, молла нарын үйл ажиллагаа, төлөв байдлын ач тустай сайн талыг ч, дутагдал доголдол, бэрхшээл зөрчлийг ч ямар нэг хэмжээгээр бодитойгоор тусгаж илэрхийлж байгаа юм.

Шашны үзэл төсөөлөл, зан үйл нь цаашдаа ямар чиглэл хандлагатай болох, тэд өөрсдийнхөө шашны мэдлэг боловсрол, зан үйлийн ёс жаягийг дээшлүүлж жинхэнэ сүсэгтэн мусульман болох хүсэл сонирхол нь цаашдаа шашны боловсрол, мэдлэгийг ямар нэг хэлбэр, арга замаар эзэмших, зан үйлийг ёсоор нь сурч мөрдөх сонирхолтой байгаа нь харагдана.

Монголын казахуудын шашин шүтлэгийн байдлыг тус орны бусад аймаг, бүс нутаг, угсаатан ястны шашин шүтлэгтэй харьцуулахад зарим онцлог шинж, өвөрмөц байдал ажиглагдаж байна. Тухайлбал, шашны социологич С.Цэдэндамбын 1994 онд тус орны 8 аймаг, Улаанбаатар хотын нийт 1800 хүнийг хамруулж хийсэн судалгаанаас үзэхэд Баян-Өлгий аймгийн хүн амын 83,5 хувь нь шашин шүтлэгтэй байгаа нь сүм хийд, хурал номын газар ихтэй бусад аймгуудын хүн амын шашин шүтлэгийн түвшингээс нэлээд дээгүүр байна. Казахуудын шашин шүтлэг халх, буриад, дөрвөд зэрэг ястнуудын шүтлэгийн түвшин байдлаас илүү үзүүлэлттэй байна. Жишээлбэл казахуудын дотор шашин шүтлэг 83,5 хувьтай байхад халхуудын дотор тэр үзүүлэлт 69,3 хувь, буриадуудад 79,9 хувь, дөрвөдүүдэд 68,4 хувь, бусад ястных 60,6 хувьтай байна.⁸

Ислам шашин зонхилсон бүс нутгийн орнуудаас Монгол дахь казахуудад энэхүү уламжлалт шашныг дахин сэргээж хүчтэй дэлгэрүүлж гүнзгийрүүлэх талаар чармайж байгаа боловч газар зүйн байршил хол, мөн казахуудын аж төрөх ёс, соёл, хэл, зан заншил, тэдгээр орнуудынхаас ялгаа онцлогтой байгаа гэх зэрэг хэд хэдэн хүчин зүйл тэдний нөлөөллийг саармагжуулж байгаа тал байна.

Казахуудын ислам шашин шүтлэг өөрийнхөө ёс жаягаараа хэвийн байдлаар сэргэж өрнөх, зохих үүргээ биелүүлэхэд нэг талаас төр, засаг захиргааны байгууллагууд шашин шүтлэгийн үйл явц, асуудлыг тус улсын хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй байлгах, зохицуулан чиглүүлэх, нөгөө талаас хүн ард, шүтлэгтнүүд өөрсдөө ислам шашны зорилго, асуудал, зөрчил

бэрхшээлийг зохиомлоор дэвэргэлгүй, асуудалд бодитой, ухаалаг, үндэстэй хандаж байгаа болно.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Баян-Өлгий аймгийн хүн амын тооллогын дүн. УБ. 2002. т.9
2. Үүнд, түүхч эрдэмтэн Х. Ислам, М. Хурметхан, К. Бикумар, А. Минис, Х. Зардыхан, А. Сарай г.м хүмүүсийн бүтээлийг дурдаж болно.
3. У. Акыт “Гахилия”, Ө., 1994. “Хажы баян” 1991. г.м.
4. Халыкүни. 2002. No.1.Улаанбаатар
5. МАХН-ын ТХ-ны тогтоолын эмхэтгэл. No.26. УБ., 1978. т.23-26
6. А.Жамбал. Ислам: Шашин. Философи. Казахуудын нийгмийн сэтгэлгээ, шүтлэг. УБ., 1999. т.144
7. мөн тэнд. т.145
8. мөн тэнд. т.153